

## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ШШГЕГ-ын харьяа ШШГГ 445 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/130/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Дархан-Уул аймаг  
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**  
Утас: **7037-3089, 9902-3869**  
Цахим хаяг: **Munkhbayarsh@audit.gov.mn**  
Аудитор: Ч.Гантулга  
Утас: **9937-2297**  
Цахим хаяг: **GantulgaCh@audit.gov.mn**



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР**

40000 Дархан-Уул аймаг  
Дархан-Уул 14-р баг  
Утас: 7517-6114, 6465, 6276, 7517-6465  
E-mail: darhan@audit.gov.mn

2021.02.31 № 119

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

ШШГЕГ-ЫН ХАРЬЯА ШШГТ 445 ДУГААР  
НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН ЗАХИРАГЧ  
С.ЛХАГВАСҮРЭН ТАНАА



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа ШШГТ 445 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын харьяа ШШГТ 445 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуурсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохиистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж, болох бөгөөд дангаараа зөвөл нийлээд үг санхүүгийн тайланд үндэслэл гаргах зорилгын эдийн засгийн шийдвэрт нөлөөлдөг үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МБМХБАГП

009020103

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мян.төг/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	300,287.2	323,229.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,512,899.5	3,541,336.4
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,813,186.7</b>	<b>3,864,566.3</b>
	Нийт өр төлбөрийн дүн	9,413.9	32,599.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,803,772.7	3,831,966.5
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,813,186.7</b>	<b>3,864,566.3</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,811,801.5	1,902,994.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,977,585.1	1,874,800.8
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(165,783.7)</b>	<b>28,193.8</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(165,783.7)</b>	<b>28,193.8</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>213,648.0</b>	<b>241,841.8</b>
	Тайлант оны үр дүн	(165,783.7)	28,193.8
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>3,804,675.3</b>	<b>3,831,966.5</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,770,372.9	1,744,505.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,766,679.3	1,693,313.9
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>3,693.6</b>	<b>51,191.8</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(6,140.0)</b>	<b>(46,481.3)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	(2,446.4)	4,710.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,034.7	6,588.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,588.3	11,298.8
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	1,505,656.0	1,504,774.2
	Урсгал зардал	1,505,656.0	1,504,774.2
	Хөрөнгийн зардал		
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	1,505,656.0	1,504,774.2
	Улсын төсвөөс санхүүжих	1,355,524.1	1,354,642.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	150,131.9	150,131.9

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

ШШГЕГ-ын харьяа ШШГГ 445 дугаар нээлттэй хорих анги нь Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ашиглалтыг эрчимжүүлэх зорилготойгоор 1 зорилт 3 чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

## **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## **Дөрөв. Аудитын гол асуудал**

ШШГЕГ-ын харьяа ШШГГ 445 дугаар нээлттэй хорих анги нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

## **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны мэдээлүүлэх зохих 141 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Хоол хүнсний 184,794.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 21, 47, 49 дүгээр зүйлүүдтэй нийцэхгүй байна.

## **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## **Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 189,780.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

### **1. Залруулсан алдаа**

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

### **2. Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### **3. Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

### **4. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Орлоготой холбоотой асуудал

### 1.1. Илрүүлэлт:

Төрийн өмч хөрөнгийг түрээслүүлэн 4,984.6 мянган төгрөгийн түрээсийн орлого олсон боловч түрээсийн гэрээ байгуулаагүй нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын 1.7-д “Түрээслүүлэгч болон түрээслэгчийн хоорондын харилцааг хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу байгуулсан түрээсийн гэрээгээр зохицуулна”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын “Түрээсийн төлбөрийн хэмжээг тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

### 1.2. Өгсөн зөвлөмж:

Тогтоол шийдвэрийг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

## 2. Орлоготой холбоотой асуудал

### 2.1. Илрүүлэлт

Хоригдлыг аж ахуйн нэгж байгууллагад хөлсөөр ажиллуулахдаа гэрээ байгуулсан боловч гэрээ дүгнэсэн актыг үйлдээгүй нь ажил гүйцэтгэх гэрээний заалт “талуудын хүлээх хариуцлага”-ыг биелүүлээгүй байна.

### 2.2. Өгсөн зөвлөмж

Ажил гүйцэтгэх гэрээний заалтуудыг биелүүлж, гэрээг дүгнэж байх

## 3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

### 3.1. Илрүүлэлт

Хоол хүнсний 184,794.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 21, 47, 49 дүгээр зүйлүүдтэй нийцэхгүй байна.

### 3.2. Өгсөн зөвлөмж

Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулж, анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлж байх



Дүн										
<b>НИЙТ ДҮН</b>	<b>3</b>	<b>189.8</b>							<b>3</b>	<b>189.8</b>